



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2017 оны 02 сарын 15 өдөр

Дугаар А/17

Улаанбаатар хот

Зочид буудал, дэн буудал, амралтын
газрын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл
олгох, цуцлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь заалт, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2011 оны 120 дугаар тогтоолоор батлагдсан "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам"-ын 5.1, Нийслэлийн Аялал жуулчлалын газрын дүрмийн 2.5.3-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам" болон "Аялал жуулчлал дэн буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS5738:2007" стандартын шаардлагыг хангасан, энэ тушаалын хавсралтад дурдсан арван нэгэн иргэн, аж ахуйн нэгжид дэн буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгосугай.

2. Энэ тушаал гарсантай холбогдуулан Иргэн Н.Ганнайрамдал "Солонго" дэн буудлын 13/257, Хан Тольт ХХК "Ателла" дэн буудлын 13/249, МЦ ХХК "Хаанчлал" дэн буудлын 13/283, Ногоон туяа ХХК "Ногоон туяа" дэн буудлын 14/101, Вайт Анжел ХХК "Анжел" дэн буудлын 14/37, Асгат жавхланта ХХК "Эрмүүн" дэн буудлын 13/80, Иргэн Ч.Даваахүү "Таван-Од" дэн буудлын 13/275, Иргэн Б.Батбаяр "Вегвайсер" дэн буудлын 15/105 тоот гэрчилгээг хүчингүй болсонд тооцсугай.

3. Гэрчилгээний үнэ болох 5000 /таван мянга/ төгрөгийг байгууллага болон иргэн тус бүрээс хураан, Төрийн сан банкны 100200051053 тоот дансанд төвлөрүүлэн, зөвшөөрлийн гэрчилгээний бичилт, олголтод байнгын хяналт тавьж ажиллахыг ахлах нягтлан бодогч /Г.Цэрэннадмид/-д даалгасугай.

4. Зөвшөөрөл авсан байгууллага болон иргэд нь гэрээ байгуулж үр дүнг тооцон ажиллахыг Захиргааны хэлтэс /Д.Ганболд/-д үүрэг болгосугай.

5. Энэхүү тушаалыг нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар, нийслэлийн Цагдаагийн газар болон дүүргүүдийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлэхийг хяналт, шинжилгээ, үнэлгээ хариуцсан мэргэжилтэн /М.Наранцэцэг/-д үүрэг болгосугай.

ДАРГА  Д.БАТСҮХ

1150500068

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын даргын 2017 оны 02 сарын 15-ны өдрийн А/17 дугаар тушаалын хавсралт

ДЭН БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН
ЖАГСААЛТ

2017.02.15

Улаанбаатар хот

Д/д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Эзэмшигчийн регистрийн дугаар	Оноосон нэр	Байршил
1	Иргэн Н.Ганнайрамдал	УХ69021062	Солонго	Сонгино хайрхан дүүрэг, 16-р хороо 3-р үйлчилгээний төв
2	Иргэн Д.Отгонбаатар	ВЮ83012571	Д центр	Сонгино хайрхан дүүрэг, 30-р хороо Хамба 2-20 тоот
3	Хан Тольт ХХК	5498732	Ателла	Сонгино хайрхан дүүрэг, 4-р хороо толгойт-78
4	МЦ ХХК	2056577	Хаанчлал	Баянзүрх дүүрэг, 13-р хороо ЭТӨ 111 тоот
5	Ногоон туяа ХХК	5669782	Ногоон туяа	Сонгино хайрхан дүүрэг, 21-р хороолол 27-р хороо толгойт 10 тоот
6	Вайт Анжел ХХК	5573343	Анжел	Чингэлтэй дүүрэг, 2-р хороо чойбалын гудамж
7	Л.Гантулга	ДИ88120613	Од	Сонгино хайрхан дүүрэг, 6-р хороо 3/34а
8	Д.Өсөхбаяр	АМ74022000	Мини	Баянгол дүүрэг, 5-р хороо 45-р байр 49,50 тоот
9	Ч.Даваахүү	ЧГ76030114	Таван-Од	Сонгино хайрхан дүүрэг, 6-р хороо 58в байрны баруун талд
10	Асгат жавхлант ХХК	5538564	Эрмүүн	Баянгол дүүрэг, 13-р хороо 2в-88
11	Б.Батбаяр	ФБ84111030	Вегвайсер	Сонгино хайрхан дүүрэг, 15-р хороо Өнөр хороолол 51 тоот

---ooOoo---